

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ,
ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН
СУДЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар
2020 он

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН¹

Ерөнхий мэдээлэл

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг нийгмийн хөгжлийн чиг хандлагатай холбоотойгоор Монгол Улсын Их Хурал, Засгийн газрын тавьж ирсэн чиглэл, зорилтын хүрээнд өөрчлөх, Монгол Улсын Үндсэн хууль болон эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүй дахь суурь зарчимд нийцүүлэх ажлын хүрээнд 2017 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг шинэчлэн баталсан.

Шинэчлэлийн нэг том алхам нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг оруулж ирсэн явдал. Мөрдөн байцаалтын шатанд хийгдэх ёстой ажиллагаанууд дутуу хийгдсэн, яллагдагчийн эрх зөрчигдсөн асуудал байгаа эсэхийг шүүх урьдчилсан хэлэлцүүлгээр шийдвэрлэж, нэмэлт мөрдөн байцаалт хийх шаардлагатай гэж үзвэл прокурорт буцаах зохицуулалт юм. Ингэснээр шүүхийн хэлэлцүүлгийн шатнаас эрүүгийн хэргийг прокурорт буцаахгүй, давж заалдах болон хяналтын шатны шүүх хэргийг прокурорт, мөрдөн байцаалтад буцаахгүй болсон байжээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг засаж сайжруулах энэхүү ажлын хүрээнд мэтгэлцэх зарчмыг тусгайлан хуульчилж, эрүүгийн хэргийг шүүхийн хэлэлцүүлгийн шатнаас буцаах зохицуулалтыг халж, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “...эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй. ...гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.” гэх шударга шүүхээр шүүлгэх эрх болон гэм буруугийн зарчмыг бататгажээ.

2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Давж заалдах шатны шүүх шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг өөрчлөн ялыг хөнгөрүүлж, эсхүл шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, хүндрүүлж болно.” гэж заасны “... **хүндрүүлж** ...” гэсэн, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад “шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;” гэж заасны “... **эсхүл хүндрүүлж** ...” гэсэн, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтад “шүүгдэгчид холбогдох хэргийн нөхцөл байдал, зүйлчлэлийг өөрчлөхгүйгээр ялыг хөнгөрүүлж, эсхүл хүндрүүлж шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулах;” гэж заасны “... **эсхүл хүндрүүлж** ...” гэсэн нь Үндсэн хуулийн холбогдох зүйлийг зөрчсөн гэж Үндсэн хуулийн цэцийн 2019 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн

¹ Судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу боловсруулав.

авсантай холбогдуулан боловсруулсан төслийг хэлэлцэн батлахдаа Цэцийн уг шийдвэрээр огт хөндөөгүй асуудлаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулсан байна.² Тодруулбал, давж заалдах шатны шүүх болон хяналтын шатны шүүх шүүгдэгчид холбогдох зүйлчлэлийг хүндрүүлэх нь Үндсэн хууль зөрчсөн талаарх шийдвэрийн дагуу хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг, хяналтын шатны шүүх анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг прокурорт буцаах талаар тусдаа зохицуулалтыг баталжээ.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зорилт нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршиж байсан бол 2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилт гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон **шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх**, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршиж байна. 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр шинжлэх ухааны үндэслэлтэйгээр халсан хэргийг нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр давж заалдах болон хяналтын шатны шүүхээс эрүүгийн хэргийг буцаах зохицуулалтыг сэргээсэн нь шинэ хуулийн зорилтыг хангах хүрээнд хийгдсэн томоохон өөрчлөлт алхмаас ухарсан явдал болов.

Иймд уг асуудалтай хамааралгүй Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр халхавч хийгдэж батлагдсан зохицуулалтыг өөрчилж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг холбогдох хуулийн зорилт, түүнд шигтгэсэн зарчимтай уялдуулах зайлшгүй шаардлагатай байна. Ингэснээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг Үндсэн хууль, эрүүгийн болон эрүүгийн процессын суурь зарчим, тэдгээрээр хамгаалагдсан үнэт зүйлд нийцүүлэн явуулах нөхцөл хангагдах юм.

Ийнхүү Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын³ дагуу хийж гүйцэтгэлээ.

² 2019 оны 04 сарын 25 өдөр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Монгол Улсын Их Хурлын 2019 оны Хаврын ээлжит чуулганы Хууль зүйн байнгын хорооны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээс дэлгэрүүлэн үзнэ үү. Холбоос: <http://parliament.mn/files/47554>

³ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Монгол Улс үндсэн хуульт төр, нийгмийг байгуулсан тэр цагаас эхлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зохицуулсан хуулиудад “шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр буцаах”-тай холбогдсон зохицуулалт бүхий заалтуудыг түүхийн он цагийн дараалал ёсоор нягталбал:⁴

№	Хууль	Он	Зохицуулагдсан эсэх
1	МОНГОЛ УЛСЫН ШҮҮН ТАСЛАХ ГАЗРААС АЛИВАА ХЭРГИЙГ БАЙЦААН ШИЙТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ	1926	Тусгагдаагүй
2	АЛИВАА ХЭРГИЙГ БАЙЦААН ШИЙТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ	1929	Тусгагдаагүй
3	АЛИВАА ХЭРГИЙГ ХЭРХЭН БАЙЦААХ БА ШИЙТГЭХ ТУХАЙ ХУУЛЬ	1935	Эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлсний хойно шүүхээс хавтаст хэрэгтэй танилцаад таслан шийтгэх хурал товлон зарлахаас өмнө хэргийг шүүхийн өмнөх шатанд шилжүүлж, нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаахаар хуульчилсан байна.
4	БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ	1949	Шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлтээр хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгэхээр эргүүлэн буцаахдаа 1. Шүүхийн өмнөх шатанд (260.2 болон 267.2 дугаар зүйл) 2. Анхан шатны шүүхийн шатанд (336 дугаар зүйл) 3. Давж заалдах шатны шүүхийн шатанд (384.2 дугаар зүйл) гэсэн 3 нөхцөлд шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцааж байсан байна. Хяналтын шатны шүүхээс нэмэлт ажиллагаа хийлгэхээр буцаах тухай зохицуулалт байхгүй байна. Харин энэ шатанд байгаа хэргийг хяналтын журмаар шаардан авах эрхтэй субъектууд байж

⁴ Хууль зүйн үндэсний хүрээлэн “Шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах нь” сэдэвт судалгааны тайлан 2017 он, х.4-7

			болно гэж тус хуулийн 404, 419 дүгээр зүйлүүдээр хуульчилсан байдаг байна.
5	БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ	1963	1/ урьдчилсан мөрдөн байцаалт бүрэн биш бөгөөд тэр нь шүүх хурлаар нөхөн гүйцэтгэх бололцоогүй бол, 2/ хэрэг бүртгэх буюу урьдчилсан мөрдөн байцаалт явуулах үед эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн байвал, 3/ урьд сонсгосон ял дээр өөр ял нэмж сонсгох, эсхүл ялыг хүндрүүлэх буюу жинхэнэ бодит байдлаар нь ялын төлөвлөгөөнд дурдсанаас онцын ялгаатай болгон өөрчлөх үндэс байвал, 4/ уг хэрэгт холбогдуулан өөр хүмүүсийг эрүүгийн хариуцлагад татах үндэс байгаа бөгөөд тэдний материалыг хэргээс тусгаарлаж болохгүй байвал, 5/ хэргийг буруугаар нэгтгэсэн буюу тусгаарласан тохиолдолд шүүх хэргийг буцаахдаа захиран тушаах хурал хийж, хэргийг нэмж мөрдөн байцаалгахаар прокурорт чухам ямар үндэслэлээр буцааж байгаа, юу нэмж тодруулахыг магадлалдаа тодорхой зааж байх үүрэгтэй” байв. Хэргийг нэмж шалгуулахаар буцаахдаа мөрдөн байцаагч, прокурорт чухам юуг, яаж хийхийг зааж сургах энэхүү үүрэг социалист шүүхийн тухайн нийгэмдээ гүйцэтгэж байсан чиг үүрэгтэй нь шууд холбоотой байдаг. “Хоёр дугаар шатны шүүхийн ажиллагаа” гэсэн хэсгийн “29 дүгээр бүлгийн 339 дүгээр зүйл: Таслан шийдвэрлэх тогтоолыг хүчингүй болгох, хэргийг шинэчлэн хэлэлцүүлэх ба мөрдөн байцаалгахаар буцаах Хэрэв ялыг хүндрүүлэн сонгох буюу урьд сонсгосон ялаас жинхэнэ байдлаараа онцгой ялгавартай ял сонгохоор таслан шийдвэрлэх тогтоолыг хүчингүй болгосон байвал таслан шийдвэрлэх тогтоол

			гаргасан шүүхээр дамжуулан нэмж мөрдөн байцаалгахаар прокурорт явуулна. Хэрэв хэргийг шүүхэд хэлэлцэх үед зөрчил гаргасны улмаас таслан шийдвэрлэх тогтоолыг өөрчилж байгаа бол уг хэргийг таслан шийдвэрлэх тогтоол гаргасан шүүхээр өөр бүрэлдэхүүнтэйгээр буюу өөр шүүхэд шинэчлэн хэлэлцэхээр буцаана” гэж тус тус заажээ.
6	ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ	1994	254 дүгээр зүйл: “Мөрдөн байцаалт явуулахдаа нэг талыг барьсан буюу гүйцэт биш хийсэн, эсхүл Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчсөнөөс шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг бүрэн нотолж чадаагүй гэж шүүх хуралдааны явцад үзвэл шүүх хэргийг хянан хэлэлцэхийг 30 хүртэл хоногоор хойшлуулж, нэмэлт мөрдөн байцаалт хийлгэх саналыг яллагчид тавьж болно...” гэж томъёолжээ. Гэм буруутай эсэхийг бүрэн нотолж чадаагүй үндэслэлээр шүүх нэмэлт мөрдөн байцаалт хийлгэдэг байх нь шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нотлогч шүүхийн байр суурьнаас оролцдог байсны илрэл. Нөгөө талаар “хэргийн бүрдэл дутуу” гэх үндэслэлээр хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаахыг урьтал болгодог шүүхийн хэвшмэл ажиллагааг хязгаарласан агуулгатай заалт хуульд оруулсан байна. Гэвч дээрх шинэлэг зохицуулалт бүхий хэм хэмжээг шүүхийн практикт хэрэглэхгүй байсаар ЭБШ хуульд оруулсан дараагийн өөрчлөлтөөр уул заалтыг хуульд “хасалт хийж” дараагийн хуулийг шинэчлэн баталсан байна.
7	ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ	2002	230 дугаар зүйлд: • - Хэргийг буруу нэгтгэсэн, тусгаарласан, • - Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн биш хийсэн бөгөөд түүнийг шүүх

			хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй бол, - Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад энэ хуулийг ноцтой зөрчсөн бол, - Улсын яллагч хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт хийлгэх шаардлагатай гэж үзсэн бол хэргийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтад буцаахаар шүүх тогтоол, шүүгч захирамж гаргах”-аар заажээ. Гучдугаар бүлэг: Давж заалдах шатны шүүхийн үйл ажиллагаа “315 дугаар зүйлийн 315.1.2 дахь хэсэг: Тогтоолыг хүчингүй болгож, хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт буюу анхан шатны шүүхээр хэлэлцүүлэхээр буцаах” Дөчдүгээр бүлэг: Хяналтын шатны шүүхийн үйл ажиллагаа “350 дугаар зүйлийн 350.1.3 дахь хэсэг: Тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах...”-аар тус тус хуульчилжээ. Энэ нь манай улсын тогтолцоонд хуучин байгаагүй, 1949 оноос 1963 он хүртэл үйлчилж байсан социалист нийгмийн чиг үүрэгтэй холбоотой зохицуулалт юм. Үүнийг 1963 оноос хойш халж, өөр байдлаар зохицуулсан байсныг Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өмнөх үеийн агуулга, хэлбэрээр хуульчилсан байна.
8	ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ	2017	33.3 дугаар зүйл. Хэргийг прокурорт буцаах 1.<u>Урьдчилсан хэлэлцүүлгийн үед</u> дараахь үндэслэлээр шүүх өөрийн санаачилгаар, эсхүл хэргийг буцаах тухай прокурорын санал, яллагдагч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан хэргийг прокурорт буцаахаар шийдвэрлэнэ: 1.1.хэргийг буруу тусгаарласан бол;

			1.2.шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй мөрдөн шалгах ажиллагааг хийлгэх бол; 1.3.мөрдөн шалгах ажиллагаа явуулахад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн бол. 2.Хэргийг прокурорт буцаасан шийдвэрийг прокурор, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан эсэргүүцэл бичих, гомдол гаргах эрхтэй. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг шинэчлэн өөрчлөх ажлын хүрээнд урьдчилсан хэлэлцүүлэг гэж шинэ зохицуулалт оруулж ирсэн бөгөөд хэрэг маргааныг буруу тусгаарласан, хуулийг ноцтой зөрчиж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсныг засахын тулд урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд хэргийг прокурорт буцаах зохицуулалтыг тусгайлан зүйл болгож хуульчилжээ.
9	ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ	2019	39.9 дүгээр зүйл. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр 1.Давж заалдах шатны шүүх дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана: 1.3.анхан шатны шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн бол тухайн шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцааж; 1.3.энэ хуулийн 33.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 34.7 дугаар зүйлийн 6.2-т заасан үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг прокурорт, эсхүл дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаах; <i>/Энэ заалтыг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</i>

			40.8 дугаар зүйл. Хяналтын шатны шүүхийн шийдвэр 1.Хяналтын шатны шүүх дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана: 1.3.анхан шатны болон давж заалдах шатны шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн бол тухайн шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаах; 1.3.энэ хуулийн 33.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 34.7 дугаар зүйлийн 6.2-т заасан үндэслэлээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг хүчингүй болгож, хэргийг прокурорт, эсхүл дахин хэлэлцүүлэхээр шүүхэд буцаах; <i>/Энэ заалтыг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./</i>
--	--	--	---

Үүнээс харахад социалист дэглэмтэй байсан он жилүүдийг эс тооцвол шүүхийн хэлэлцүүлгийн шатанд хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулахаар прокурорт буцаах зохицуулалт манай орны уламжлалд байгаагүй байна. 1935 онд таслан шийтгэх хурал товлон зарлахаас өмнө хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаадаг байсан. 1949-1994 оны хооронд хэргийг буруу тусгаарласан, хуулийг ноцтой зөрчиж ажиллагаа явуулсан тохиолдолд шүүхээс прокурорт хэрхэн, яаж яллах талаар чиглэл өгч, захиран тушаах хурлаар хэргийг хяналтын шатны шүүхээс бусад үе шатанд прокурорт буцаадаг байв. 1994 онд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд оруулсан нэмэлтээр шүүгдэгчийн гэм буруутай эсэхийг хангалттай нотлох боломжгүй нөхцөлд шүүх хуралдааныг 30 хүртэл хугацаагаар хойшлуулж, нэмэлт мөрдөн байцаалт хийлгүүлдэг байжээ. Энэ нь хэргийг буцаахгүйгээр хэргийн бодит байдлыг тогтоох боломж бүрдүүлсэн шинэлэг зохицуулалт болсон ч хэрэгжихгүй байсаар хууль өөрчлөгджээ.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар 1949-1963 он хүртэл үйлчилж ирсэн хуулийн зохицуулалтын агуулгыг сэргээснээс гадна хяналтын шатны шүүхээс хэргийг прокурорт буцаах гэсэн өмнө нь байгаагүй зохицуулалтыг нэмсэн нь шүүхийг дээрээс доош чиглэл өгдөг, хагас босоо тогтолцоотой болгох хүчин зүйл болсон байна.

2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах ажлын хүрээнд хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буюу прокурорт буцаах зохицуулалтын хэрэгцээ шаардлагыг судлан шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үе шатыг бий болгож, хуучин хуулийн зохицуулалтыг сайжруулах ажил хийгдсэн байна.

2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр 1949-1963 он, 2002 оны эрүүгийн процесс хуулиудад байсан зохицуулалтуудыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар сэргээсэн нь эрүүгийн эрх зүйн тогтолцоог эвдэж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хийсэн өөрчлөлт, шинэчлэлээс ухарсан явдал болсон байна.

Иймээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг Үндсэн хууль, олон улсын зарчим, хуулийнхаа зорилтод нийцүүлж, нийгмийн хөгжил, шударга шүүхийн тогтолцоо, хүний эрх, эрх чөлөөг хамгаалсан эрүүгийн процессыг бий болгоход Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай юм.

Иймд аргачлалын дагуу дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцлийг тодорхойлсон болно.

1.1. Асуудлын мөр чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах зохицуулалтыг зорилгод нь нийцүүлэн хуульчлах, зохистой ба зохисгүй туршлага, үр дагаврыг тооцох асуудал дээр Монгол Улс томоохон ухралт хийжээ.

Дэлхийн улс орнууд шүүхээс хэргийг буцаах зохицуулалтыг эрүүгийн процессын хуулиасаа хасч, мөрдөн шалгах ажиллагаа явуулах шаардлага гарсан үед шүүх ажиллагааг түдгэлзүүлэн шүүхийн шатанд явуулах бололцоог хангах эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

Манай улс 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар шүүхийн шатнаас хэргийг шууд прокурорт буцаадаг зохицуулалт хуучны социалист дэглэмийн үеийн захиран тушаах шинжийг хадгалж, хэргийг үнэн бодитой шийдвэрлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан алдаа зөрчлийг залруулах зорилгод нийцэхгүй байгааг анзаарч, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хассан. Ингэж хасахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хэргийг буруу тусгаарласан, шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй мөрдөн шалгах ажиллагааг хийлгэх шаардлагатай болон мөрдөн шалгах ажиллагаа явуулахад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн тохиолдолд **урьдчилсан хэлэлцүүлгийн үе шатанд** хэргийг прокурорт буцаах боломжтой байдлаар зохимжтой хүрээнд хуульчилсан. Өөрөөр хэлбэл, прокурор хуульд заасан үүргээ дутуу биелүүлсэн бус нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт зайлшгүй явуулах

шаардлагатай тохиолдолд хэргийг буцаах боломж бүрдүүлэхээр “урьдчилсан хэлэлцүүлгийн үе шат”-ийг шинээр бий болгосон байна.

Урьдчилсан хэлэлцүүлгийн үе шат нь прокурорын хүсэлтээр шүүхийн мөрдөн шалгах ажиллагааны бүрэн жигд, үр нөлөөт байдлыг хангаж, өмгөөллийн эрхийг хамгаалахад шаардлагатай арга хэмжээ авах зорилготой үе шат. Шүүхийн шатнаас хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад прокурорын хүсэлтийг үндэслэж буцаадаг байснаар урьдчилсан хэлэлцүүлгийн үе шат огт хэрэгжихгүй нөхцөл бий болоод байна.

Ийнхүү урьдчилсан хэлэлцүүлгийн шатнаас нэмэлт мөрдөн байцаалтад буцаагаагүй хэргийг шүүхийн шатнаас прокурорт үндэслэл заахгүйгээр буцаах, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг шууд буцаадаг байдал нь хууль зүйн үр дагавар бүхий хэд хэдэн асуудлыг үүсгэж байна.

НЭГ. ГЭМ БУРУУГИЙН ЗАРЧИМ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “...Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” гэж заасан бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Шүүхийн шийтгэх тогтоол гарах хүртэл хүн, хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд, түүнчлэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад Эрүүгийн хууль, энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтанд ашигтайгаар шийдвэрлэнэ” гэж тус тус заажээ.

1966 онд НҮБ-аас баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон улсын пактын 14-р зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэгт буруутгуулж буй хэн боловч гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугийд тооцогдох эрхтэй” гэжээ.

“Гэм буруутайд тооцох эсэх нь эрүүгийн процесс ажиллагааг явуулж буй хэн нэгний субъектив үнэлгээ, хувийн санал бодол, дүгнэлт биш, ...зөвхөн шүүх хуралдаан дээр яллах өмгөөлөх талуудыг мэтгэлцүүлэх замаар гэм буруугийн асуудлыг шүүх шийднэ”⁵ гэсэн үг юм.

Ямар ч нөхцөлд бүрэн гүйцэд нотлогдоогүй хангалттай бус баримт сэлтэнд тулгуурлаж, гэм бурууг нь урьдчилан тогтоох гэж муйхарлан оролдох, яллах нотлох баримтыг хэт дөвийлгөн шүтэх, цагаатгах баримтыг үндэслэлгүйгээр үгүйсгэх зэрэг нь энэ зарчмын агуулгыг алдагдуулах төдийгүй эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчилд тооцогдоно.⁶ Иймд анхан шатны шүүх гэм буруугийн шүүх хуралдаанаар яллагдагчийн гэм буруутай

⁵ Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хууль. Хялбаршуулсан тайлбар. Ханнс Зайделийн сан, УБ 2010 он, х.21

⁶ Д.Баярсайхан “Эрүүгийн процессын эрх зүй”, УБ 2014 он, х.105

эсэхийг тогтоон яллах эсхүл цагаатгах гэсэн шийдвэрийн аль нэгийг л гаргана. Яллагдагчийн гэм буруутай эсэх талаар эргэлзээ гарвал яллагдагчид ашигтайгаар шийдвэрлэх бөгөөд гэм буруу нь нотлогдохгүй байгаа үндэслэлээр хэргийг прокурорт буцаах нь гэм буруугийн зарчмыг зөрчдөг.

Нотлох баримтыг үнэлэхдээ яллах, цагаатгах нотлох баримтыг аль алийг гүйцэд шалгаагүй, хүний үндсэн эрхийг зөрчиж цуглуулсан нотлох баримтыг шүүх үнэлэхээс татгалзаж, цагаатгах тогтоол гаргана. Харин гэм буруутай эсэх нь гэм бурууг хэлэлцэх шүүх хуралдаанаар тогтоогдсон тохиолдолд шүүх гагцхүү шийтгэх тогтоол гаргана.⁷

Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй байхад хэргийг прокурорт буцаан зайлшгүй яллах гэж оролдох, түүнчлэн хүний гэм буруутай эсэхийг тогтоосны дараа түүнээсээ буцаж, цагаатгах тогтоол гаргахгүйгээр хэргийг прокурорт буцаах нь гэм буруугийн зарчимд харшилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг ноцтой зөрчиж байна. Мөрдөгч, прокурор өөрийн гаргасан алдааг шүүхээс чиглэл, заавар авсны дараа залруулж, хуульд заасан чиг үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйгээс болж шүүгдэгчийн эрх ноцтой зөрчигддөг.

Иймд нотлох баримт цуглуулж, бэхжүүлэхдээ хуульд заасан журмыг зөрчсөн талаар гомдол гарсан, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн талаар гомдол гарсан, энэ талаар урьдчилсан хэлэлцүүлгийн үед авч хэлэлцээгүй орхигдсон тохиолдолд хэргийг прокурорт нэмэлт мөрдөн байцаалтад шууд буцаахгүйгээр шүүхийн шатанд тухайн гомдлыг авч хэлэлцэх нь гэм буруугийн зарчмыг зөрчихгүйгээр мөрдөгч, прокурорын алдааг залруулж, оролцогчдын эрхийг хангах зохицуулалт болох юм.

ХОЁР. DOUBLE JEOPARDY БУЮУ ШҮҮГДЭГЧИЙН ГЭМ БУРУУГ НЭГ Л УДАА ШҮҮХЭЭР ЭЦЭСЛЭН ШИЙДВЭРЛЭХ ЗАРЧИМ

Олон улсын болон үндэсний эрүүгийн эрх зүйн тулгуур зарчим болсон *ne bis in idem* (өөрөөр double jeopardy зарчим) нь шүүхээс тухайн хүний нэг тодорхой үйлдлийн гэм буруугийн төлөө ял оноохдоо дахин яллаж болохгүй буюу шүүхээс шүүгдэгчийн гэм бурууг нэг л удаа эцэслэн шийдвэрлэх ёстой гэсэн агуулгатай.

Уг зарчмыг Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэж шударга ёсны зарчимд багтаан хуульчилжээ. Гэм буруутай эсэхийг тогтоосны дараа шүүгдэгчийн гэм буруугийн асуудлыг дахин хэлэлцэх, дахин мөрдөн шалгах ажиллагаа явуулах, байцаалт авах, дахин яллахыг хатуу хориглосон зарчим юм. Энэ үүднээс давтан гэмт хэрэг үйлдсэнийг хүндрүүлэх шинжид оруулахгүй байхаар Эрүүгийн хуулийг боловсруулан баталсан нь дэвшилт болсон.

Харин эрүүгийн процесс ажиллагаанд гэм буруутай эсэхийг шийдвэрлэх шүүх хуралдаанаар шүүгдэгчийн гэм бурууг тогтоосны дараа тэр гэмт хэрэгт нь ахиж мөрдөн шалгах ажиллагаа явуулах, түүнчлэн шүүхийн шийдвэрээр хүнд ял

⁷ Уг зарчим Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 36.2 дугаар зүйлд мөн тусгалаа олсон.

шийтгэл оногдуулсны дараа давж заалдах болон хяналтын шатны шүүх тухайн этгээдийг дахин яллуулахаар хэргийг прокурорт буцаадаг байх нь дээр дурдсан шударга ёсны зарчмыг ноцтой зөрчдөг байна.

Нэг гэмт хэрэгт нэг бус прокурорт буцаах байдлаар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусах хүртэл хэдэн ч удаа ял оногдуулах боломжтой нөхцөл байдлыг бий болгосон зохицуулалт нь шүүгдэгчийн эрх зүйн байдлыг илт дордуулах үр дагавар бий болгож байгаагаас гадна хэргээ богино хугацаанд шийдвэрлүүлэн суллагдах эрхийг зөрчдөг.

Түүнчлэн эрүүгийн хэрэг олон сар, жилээр сунжирч, гэм буруутай эсэхээ эцэслэн шийдвэрлэснийг ахин хянан хэлэлцэхээр мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь шүүгдэгчид эрүү шүүлт үзүүлэх нэг хэлбэр болж байна. Тодруулбал, шүүгдэгч гэм буруутай гэж анхан болон давж заалдах шатны шүүх шийдвэрлэсний дараа хяналтын шатны шүүхээс хэргийг прокурорт буцааж, тухайн хэрэг гэмт хэргийн шинжгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болж, шүүгдэгч гэм буруугүй гэдгээ шүүхийн шийдвэрээр нотолж чадахгүй байсаар нийгэмд эзлэх байр сууриа алдах тохиолдлууд гарсаар байна.

ГУРАВ. ПРОКУРОР БОЛОН МӨРДӨГЧИЙН ЧИГ ҮҮРЭГ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар мөрдөгч, прокурор нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж хянасны үндсэн дээр хэргийн бодит байдлыг тогтоох үүрэгтэй. Түүнчлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулийг чанд сахих үүрэгтэй.⁸

Шүүхийн хэлэлцүүлэг хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л үе шатанд мөрдөгч, прокурор хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай яллах болон цагаатгах нотлох баримтыг цуглуулан бэхжүүлдэг. Шүүхийн өмнөх бүхий л үед прокурор хуульд заасан хяналтыг тодорхой хязгаарлагдмал хүрээнд хэрэгжүүлдэг бөгөөд шаардлагатай тохиолдолд мөрдөгчид нэмэлт мөрдөн байцаалт явуулахыг даалгадаг. Ингээд яллах дүгнэлт үйлдсэн прокурор шүүх хуралдаан болох хүртэлх үе шатанд, шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үед хэргийг буруу тусгаарласан, шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй мөрдөн шалгах ажиллагааг хийлгэх шаардлагатай гэж үзэж хэргийг прокурорт буцаагаагүйгээс болж анхан шатны шүүхийн шийдвэр гарсны дараа давж заалдах болон хяналтын шатны шүүхээс яг дээрх үндэслэлээр, эсхүл прокурорын үндэслэл заагаагүй хүсэлтээр хэргийг буцаадаг байх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг алдагдуулж байна.

Мөрдөгч, прокурор ийнхүү хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд шүүхээр уг алдааг засуулдаг буруу практик тогтож ирснийг засч, хуулиар тогтоосон журам, баримталсан зарчмыг хамгаалах шаардлагатай. Үүний нэг том алхам болгож Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үе шатыг бий болгосон ч үүнийг хэрэгжүүлэхгүй

⁸ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

байгаа юм. Мөн 2019 онд сэргээсэн давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хэргийг прокурорт буцаадаг зохицуулалт нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үе шатын ач холбогдлыг бүхэлд нь алдагдуулж, мөрдөгч болон прокурорыг ноцтой алдаа гаргахыг зөвшөөрсөн, шүүгдэгчийн эрх зүйн байдлыг илт дордуулж байна.

ДӨРӨВ. ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ

Ром-германы эрх зүйн тогтолцоонд хамаардаг улсуудад давж заалдах шатны шүүх, Дээд шүүхээс доод шатны шүүхийн эрүүгийн хэргийн талаарх шийдвэртэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэхдээ доод шатны шүүх хууль зөрчсөн эсхүл хуулийг буруу хэрэглэсэн эсэхийг хянан үздэг байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.9 дүгээр зүйлийн 1.3, 40.8 дугаар зүйлийн 1.3 дахь хэсгээр давж заалдах болон хяналтын шатны шүүхийн эрх хэмжээг зохистой төвшнөөс хэтрүүлжээ. Дээд шатны шүүх нь доод шатны шүүхдээ эрүүгийн хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар чиглэл өгч байгаа байдал нь өөр өөр шатны шүүхүүд бие биеэсээ хараат бусаар шүүн таслах ажиллагаа явуулах боломжийг хязгаарлаж байна. Ингэснээр шүүхийн хараат бус байдал алдагдах, шүүхийн босоо тогтолцоо улам бэхжих үндэс суурь болсон юм.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор баталсан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид Монгол Улс 2005 онд нэгдэж орсон бөгөөд тус конвенцийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүхийн хараат бус байдал, авилгын эсрэг тэмцэл дэх түүний шийдвэрлэх үүргийг санан, оролцогч улс бүр эрх зүйн тогтолцооныхоо тулгуур зарчимд нийцүүлэн, шүүхийн хараат бус байдалд хохирол учруулахгүйгээр шүүхийн байгууллагад ажиллагсдын шударга байдлыг бэхжүүлэх, тэдгээрийн дунд авилгад автагдах боломж бий болохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна." гэж заажээ. Иймд улс төрд нөлөө бүхий этгээдийн ашиг сонирхлыг хамгаалах нөхцөл бий болгож, шүүхүүд бие биеэсээ хараат, прокурор хараат бусаар үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарлаж, авилгын сүлжээ бий болгож буй зохицуулалтыг яаралтай засах нь зүйтэй байна.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлох

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.7 дугаар зүйлийн 6.2, 39.9 дүгээр зүйлийн 1.3, 40.8 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт зааснаар хэргийг прокурорт буцаадаг зохицуулалтийн улмаас эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдийн хувьд сөргөөр нөлөөлөх байдлыг дараахь байдлаар тодорхойлж болно.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Хохирогч	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сунжирч, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм буруутай эсэхийг олон дахин хянаж үзэх нь хохирогч иргэний журмаар гомдол гарган хохиролоо гаргуулах боломжийг хязгаарлаж байна.
2	Сэжигтэн	Мөрдөгч, прокурорын алдаатай үйл ажиллагаанаас болж сэжигтэн байхаа болисон этгээд хэдийд ч, ямар ч хугацаанд дахиад сэжигтнээр татагдан шалгагдах боломжтой байх, сэжигтэн байсан хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай гэж шүүх шийдвэрлэж, сүүлд нь цагаатгахгүйгээр хэргийг прокурорт буцаан тухайн этгээдийн эрхийг ноцтой зөрчих нөхцөл бодитой бий болсон байна.
3	Яллагдагч	Яллагдагч ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх, гэм буруугаа хүлээн зөвшөөрч, өөрийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн шийдвэр гаргуулах эрхтэй. Харин шүүх хуралдаанаар нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэж зүйлчлэлийг хүндрүүлэх эсхүл шинээр ял сонсгохын тулд шүүхийн шатанд хэргийг прокурорт буцаах ерөнхий зохицуулалтыг хэрэглэж байгаа нь яллагдагч дээрх эрхээ бодитой эдлэх боломжийг хязгаарлаж байна.
4	Шүүгдэгч	Шүүгдэгчид шүүхээс ял оногдуулсны дараа дээд шатны шүүээд шүүгдэгчийг цагаатгахгүйгээр хэргийг прокурорт буцааж, хэргийг хэрэгсэхгүй болгох нь гэм буруугийн болон шударга ёсны зарчимд нийцээгүй хүний эрхийн ноцтой зөрчил болж байна.
6	Өмгөөлөгч	Өмгөөлөгч шүүхийн хэлэлцүүлгийн явцад бүхий л үндэслэлээ гаргаж яллах талтай мэтгэлцсэний дараа шүүх шийдвэр гаргахгүйгээр прокурорын үндэслэл заагаагүй хүсэлтийн үндсэн дээр хэргийг прокурорт буцааж, прокурор ямар ч аргаар хамаагүй яллах байр суурьнаас оролцохыг эрмэлзэх нь мэтгэлцэх зарчмыг зөрчиж байна.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Монгол Улсын Үндсэн хууль, эрүүгийн болон эрүүгийн процессын эрх зүйн зарчимд нийцэхгүй зохицуулалтыг сэргээж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хийсэн шинэчлэлийг онолын чиг баримжаагүйгээр эвдсэн нь Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас хийх эрх зүйн шинэтгэлд эргэлзэгчдийг

нэмэгдүүлж, тодорхой зохицуулалтаас хамаарч бүтэн тогтолцоо гажуудах нөхцлийг бий болгожээ.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 17 дугаар зүйлд “...шүүгдэгчид сонсгосон ялыг нотлох үүргийг прокурор хүлээх”, мөн хуулийн 16 дугаар зүйлд “...прокурор, шүүх нь хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой нотлохын тулд ...нөхцөл байдлыг бүрэн тогтоох үүрэгтэй”-г хуульчилсан. Эндээс үзвэл 2017 он хүртэл прокурор төдийгүй шүүх ч хэргийн байдлыг нотлох үүрэгтэй байв. Мөн хуулийн 230.1.2-т хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн биш хийсэн түүнийг шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй бол шүүх хэргийг нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр буцаахаар зохицуулж байсан нь нэг талаас хэргийг мөрдүүлж хийлгэхээр нотлогч шүүхийн шаардлага буюу мөрдөн байцаалтын дутууг шүүх нөхдөг гэсэн ойлголтыг өгсөөр иржээ.

Учир нь өмнөх социалист тогтолцооны үед шүүх бодит үнэнийг тогтоох зарчмыг хангах үүднээс талуудыг байцааж нотолгоо бүрдүүлэх буюу улсын яллагчийн нотолгоо хангалттай эсэхийг шалгах замаар дутууг нөхөн ялладаг байсан нь шүүх бодит үнэнийг тогтоох зорилго бүхий нотлогчийн шинжийн илэрхийлэл байв.

2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар шүүх хуралдаанаар хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтоох шаардлагын улмаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн биш хийсэн үндэслэлээр буюу дутууг өөрөөр нь гүйцээлгэх зорилгоор шүүхээс буцаадаг байсан нь нотлогч шүүхийн социалист хэв маягийг хадгалсаар байсан.

Энэ онцлогыг харгалзан 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар шүүхийн шатанд шүүхийн хяналтыг бий болгосон нь шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн механизм юм. Нотлогч шүүхийн хэв маягаас салахын тул эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үндсэн зарчим болох мэтгэлцэх зарчим бодитой хэрэгжих хэрэгтэй. Учир нь мэтгэлцүүлэн шударга ёсыг тогтоох зорилго бүхий Англи-Америкийн тогтолцоотой хэрэг хянан шийдвэрлэх журмыг мөрдөн шалгаж бодит үнэнийг тогтоох Эх газрын тогтолцоонд ухаалгаар уялдуулах замаар тогтолцооны гажуудлыг байнга засварлаж байх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны холимог тогтолцоо бүхий манай орны эрүүгийн процессын цаашдын хөгжлийн зорилго байх учиртай⁹ байна.

Харин өмнөх дэглэмийн үед байсан нотлогч шүүхийн чиг үүрэг болсон шүүхийн шатанд хэргийг прокурорт буцаах зохицуулалтыг Үндсэн хуулийн цэцийн уг асуудалд хамааралгүй шийдвэрээр халхавч хийн сэргээсэн нь 2017 онд хийсэн эрх зүйн шинэчлэлээсээ ухрахаас гадна эрх зүйн тогтолцооны засрашгүй гажуудалд хүргэх аюултайг анхаарах шаардлагатай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нийтлэг, үндсэн зорилтын агуулга нь дараах хоёр чиглэлээр илэрхийлэгдсэн байдаг. Үүнд:

⁹ Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан “Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал”, УБ 2018 он, х.304

- 1) Гэмт хэргийг бүрэн, шуурхай илрүүлэн, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах **/яллах үйл явцыг хангах зорилт/**
- 2) Гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх явдлыг хангах **/цагаатгах үйл явцыг хангах зорилт/¹⁰**

Уг хоёр зорилт нэг нь нөгөөгөө нөхөж, эрүүгийн процесс ажиллагааны тэнцвэртэй шударга байдлыг хангахад чиглэдэг. Хэргийг шүүхийн шатнаас, түүнчлэн давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хүний гэм буруутай эсэхийг шийдвэрлэсний дараа эхнээс нь мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж, тухайн хүнийг гарцаагүй яллах ёстой гэсэн хандлагаар авч үзсээр байгаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ноцтой зөрчиж буй зохицуулалтаас татгалзахгүй байх үндэслэл болсон. Шүүх, прокурор эрүүгийн процесс ажиллагааны үндсэн зорилтын хоёр агуулгыг тэнцвэртэй баримталж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар бий болгосон шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийг ашиглаж, хууль зөрчсөн алдааг засах зорилгоор хэргийг урьдчилсан хэлэлцүүлгээс буцаадаг нөхцлийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр яллагдагчийн гэм буруу, эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой асуудлыг хэлэлцэхгүй. Урьдчилсан хэлэлцүүлгийн үед хэргийг буруу тусгаарласан, шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй мөрдөн шалгах ажиллагааг хийлгэхээр, мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн үндэслэл байна гэж үзвэл шүүх өөрийн санаачлагаар, эсхүл хэргийг буцаах тухай прокурорын санал, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан хэргийг прокурорт буцаахаар шийдвэрлэнэ.¹¹

Гэтэл шүүх, прокурор эрүүгийн процесс ажиллагааны зорилтын яллах үйл явцыг хангах зорилтыг цагаатгах үйл явцыг хангах зорилтоос дээгүүр тавих, хэргийн оролцогчдийн мэтгэлцээнээс хамааралгүйгээр хэргийг шүүх үзэмжээрээ чиглүүлэх, дээд шатны доод шатны шүүхдээ чиглэл өгч, гаргасан шийдвэрийг нь бүхэлд нь үгүйсгэдэг явдал ихэссээр байна.

¹⁰ Д.Баярсайхан “Эрүүгийн процессын эрх зүй”, УБ 2014 он, х.67

¹¹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 33.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

Монгол Улсын Ерөнхий Прокурорын газраас мэдээллэсэн “Прокурорын санал, давж заалдах, хяналтын шатны шүүх хуралдаанаас прокурорт болон анхан шатны шүүхэд буцсан хэргийн тоон судалгаа”

Хүснэгт 1

2017.07.01-2020.08.20 өдрийн байдлаар

Он	ЭХХШТХ-ийн 34.7.6.2-т зааснаар прокурорын яллахаас татгалзаж, прокурорт буцаах тухай санал	Давж заалдах шатны шүүхээс ЭХХШТХ-ийн 39.9.1.3-т зааснаар буцаасан			Дээд шүүхээс ЭХХШТХ-ийн 40.8.1.3-т зааснаар буцаасан		
		нэмэлт мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгүүлэхээр прокурорт	дахин хэлэлцүүлэх ээр анхан шатны шүүхэд буцаасан	Нийт	нэмэлт мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгүүлэхээр прокурорт	дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан	Нийт
2017	1	0	1	1	1	1	2
2018	6	13	19	32	0	1	1
2019	4	95	358	453	25	34	59
2020	5	64	144	208	11	9	20
Нийт	16	694			82		

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд 2019 онд өөрчлөлт оруулснаас хойш давж заалдах шатны шүүхээс уг хуулийн 39.9.1.3-т заасныг үндэслэж 661 хэргийг буцаасан бол хяналтын шатны шүүхээс 40.8.1.3-т заасныг үндэслэж 79 хэрэг буцаасан байна. Үүнээс харахад шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа шүүгдэгчийн гэм бурууг эхнээс нь дахин хэлэлцэж, прокурор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны туршид нэмэлт мөрдөн байцаалт явуулахаар хэргийг мөрдөгчид буцааж, хэргийн нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай бүхий л ажиллагааг хийх хуульд заасан чиг үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байгаа нь харагдаж байна.

Дээд шатны шүүхээс доод шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь үгүйсгэх замаар хянах, хэргийг хэрхэн шийдвэрлэх талаар чиглэл өгч байгаа нь авилгын сүлжээ, шүүхийн хагас босоо тогтолцоо бий болох орон зайг улам бэхжүүлж байна. Өмнөх тогтолцооны үед хэргийн нөхцөл байдлыг тогтоох чиг үүргийг шүүх, прокурор хэрэгжүүлдэг байсан бол одоо мөрдөгч, прокурор зохистой хэрэгжүүлэх үүрэгтэйг ухамсарлах шаардлагатай билээ. Түүнчлэн шүүх хуралдаан дээр талуудын мэтгэлцээний үр дүнд яллагдагчийг зөвхөн яллах байр суурьнаас бус хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс сайтар хянаж, шүүх шийтгэх эсхүл цагаатгах тогтоолын аль нэгийг гаргадаг байх нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шударга, хууль ёсны явагдах гол нөхцөл болно.

Эрүүгийн хэрэг нь хүний үндсэн эрхийг шууд хөнддөг бөгөөд хэргийн оролцогчдод төрийн албадлагыг хэрэгжүүлэх үндэслэл болж өгдөг учир мөрдөгч, прокурорын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гүйцэтгэх үүрэг тэр хэмжээгээ өндөр хариуцлагатай байна. Шүүхийн шатнаас, давж заалдах болон

хяналтын шатны шүүхээс хэргийг прокурорт буцаадаг заалт нь мөрдөгч, прокурорын дээр дурдсан үүргээ зохих ёсоор биелүүлэхгүй байх нөхцлийг бүрдүүлэхээс шүүгч, прокурор авлига авах, хэргийг түргэн шуурхай шийдвэрлэхгүйгээр хэргийн хөөн хэлэлцэх хугацааг дуусгах байдлаар гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял завших боломжийг бий болгожээ.

Иймд эрх зүйн хийдэл, зөрчилтэй зохицуулалтыг засаж залруулахаас гадна мөрдөгч, прокурор хуульд заасан үүргээ шударгаар биелүүлэхийг эрмэлзэн шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлж, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасан зорилтод нийцсэн байдлаар явагдах боломжийг бүрдүүлэх хэрэгтэй байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Хуулийн төслийг боловсруулах зорилго нь 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг өөрийн зорилго, үзэл баримлал, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан гэм буруугийн зарчим, шүүх, прокурорын гадны нөлөөнд автахгүй байх зарчим, шүүгдэгчийн гэм бурууг нэг л удаа шүүхээр эцэслэн шийдвэрлэх шударга ёсны зарчмыг ноцтой зөрчиж, гэм буруутай этгээдэд ял завших боломж олгож буй хуулийн хийдлийг залруулах, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар боловсронгуй болгосон зарчимд нийцүүлэн явуулах нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Хүснэгт 2

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдсан асуудал, хуулийн хийдэл, зөрчил арилахгүй үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч хуулийн хийдлийг засаагүйгээс төр, иргэн, хуулийн этгээдэд учрах хохирлын хэмжээ нэмэгдсээр сөрөг үр дагавар ихсэнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр	Зорилгыг хангах боломжгүй бөгөөд хувийн ашиг	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж	Үр дүн сөрөг

	ухуулга, сурталчилгаа хийх	сонирхол бүхий этгээдүүдийн шүүх, прокурорт нөлөөлөх нөлөөллийг бууруулах, иргэдийн эрхийг хамгаалах, эрүүгийн процесс ажиллагааны зөрчлийг арилгахад бодитой нөлөөлж чадахгүй.	буй шалгаан, нөхцлийг арилгахгүй.	
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Төрөөс зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглах зохицуулалт хийх боломжгүй. Шүүх гагцхүү хуульд захирагдаж шүүн таслах ажиллагаа явуулдаг тул үүнд нөлөөлөхгүй.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж буй шалгаан, нөхцлийг арилгахгүй.	Үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенци хийх	Төрөөс интервенци хийх шаардлагагүй.	Тодорхой хэмжээний зардал гарна. Асуудлыг үүсгэж буй шалгаан, нөхцлийг арилгахгүй.	Үр дүнд хүрэхгүй
5	Захиргааны шийдвэр гаргах	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хуульд заасны дагуу явагдах тул захиргааны шийдвэр гаргах нь үр дүнгүй байна.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгаан, нөхцлийг арилгахад нөлөөлж чадахгүй.	Үр дүн сөрөг
6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгаар оруулсан дэвшил, өөрчлөлтийг эвдсэн, Үндсэн хууль,	Зардал гарахгүй бөгөөд асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлнэ.	Үр дүнтэй

		Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилго, зарчмыг зөрчсөн хуулийн хийдлийг засах боломж бүрдэнэ. Ингэснээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогчдийн эрх зөрчигдөх, шүүхийн босоо тогтолцоо бий болох, авилга өгөх зэргийг таслан зогсоох, улс төрийн эрх бүхий албан тушаалтнаас хөндлөнгөөс эрүүгийн хэрэгт оролцох нөлөөллийг хаах нөхцөл бий болно.		
--	--	---	--	--

Аргачлалын 5.4.1-д тухайн асуудал нь хүний салшгүй эрхэд буюу Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан хүний эрхийг хязгаарлах бол хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгоно гэж заасан.

Асуудал нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт "...эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх эрхтэй. ...гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно." гэж заасан хүний салшгүй эрхийг хөндөж байх тул хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарыг шууд сонгоно. Энэ тохиолдолд анхдагч хуулийн төсөл боловсруулахгүй, одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хийдэл, зөрчилтэйгээр хэрэгжин зорилго, зарчимдаа нийцэхгүй удаан явах нь эрүүгийн эрх зүйн тогтолцоонд сөрөг үр дагавар бий болгож, иргэдийн үндсэн эрх зөрчигдөж, нийгмийн шүүхэд итгэх итгэлийг ихээр эвдэх тул Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах шаардлагатай байна.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг үнэлгээний тайланд хавсаргасан хавсралт 1, 2, 3, 4-өөс үзнэ үү.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүний эрх ноцтой зөрчигдөж буй асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ, шаардлага байна.

Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй болно.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Нэмэлт зардал гарахгүй бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч иргэнд эрхээ эдлэх боломж нөхцлийг бүрдүүлнэ. Их хэмжээний хохирол учруулсан эрүүгийн хэрэгт ял завших боломжийг хааснаар хохирлыг барагдуулж, улсын төсөвт эерэг нөлөө үзүүлнэ.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Гэм буруутай, гэм буруугүй гэж олон дахин гэм буруугийн асуудлыг авч хэлэлцдэг хүний эрхийн зөрчлийг арилгаж, ганцхан яллах талын байр суурьнаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагддаг практикийг засна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түргэн, шуурхай, шударга явагдахад эерэг нөлөө үзүүлж, мөрдөгч, прокурор хуульд заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгэх шаардлагыг бэхжүүлж буй тул шүүх эрх мэдэлд итгэх олон нийтийн итгэлийг бий болгоно.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд ба шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсэгт “...Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг

үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” гэж заасан тул хуулийн төсөл боловсруулахаар сонгосон хувилбар нь Үндсэн хуулийн зарчимд нийцэж байна.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Баривчлагдсан буюу эрүүгийн хэрэгт буруутгагдсан аль ч хүнийг шүүгч буюу хуулийн дагуу шүүн таслах эрх хэмжээ олгогдсон бусад албан тушаалтанд даруй шилжүүлэх бөгөөд хүн хэргээ богино хугацаанд шүүхээр шийдвэрлүүлэх буюу суллагдах эрхтэй...” гэж, Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 10 дугаар зүйлд “Хүн бүр тулгасан аливаа эрүүгийн ял болон эрх үүргээ тодорхойлуулахдаа хараат бус, тал хардаггүй шүүхээр бүрэн адил тэгш үндсэн дээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй” гэж тус тус заасантай нийцнэ.

Мөн Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна” гэж заасан шударга ёсны зарчимд нийцэж байх тул хуулийн төсөл боловсруулах нь зүйтэй байна.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Аргачлалын 7-д зааснаар хувилбарын эерэг болон сөрөг талуудыг

- Зорилгод хүрэх байдал;
- Зардал, үр өгөөжийн харьцаа;
- Хүний эрх, эдийн засагт, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө;
- Хууль тогтоомжтой нийцэж буй эсэх;
- Гарч болох сөрөг үр дагавар, түүнийг арилгах хувилбар байгаа эсэх гэсэн шалгуураар дахин нягтлан үзэж дараах дүгнэлтийг хийлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн зарчим, Олон улсын хэм хэмжээний жишиг зэргийг харьцуулан дүгнэхэд дурдсан асуудлуудыг хууль боловсруулах замаар шийдвэрлэх боломжтой байна.

ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Дэлхийн эрх зүйн системд монголын үндэсний эрх зүйн хамаарал, эх газрын эрх зүйн системтэй улсуудын хууль тогтоомжийн үндэсний хууль тогтоомжид үзүүлсэн нөлөө, монголын мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагааны уламжлалт хэв маяг, түүнчлэн эрх зүйн шинэчлэлийг амжилттай хийсэн зарим улсын хууль тогтоосон туршлага, онцлог зэргийг харгалзан ОХУ, Латви, ХБНГУ, Франц Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийг харьцуулан судалсныг товчлон танилцуулбал:

ОХУ-ЫН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ

Оросын Холбооны Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 237 дугаар зүйлд зааснаар “Эрүүгийн хэргийг прокурорт буцаах” тухай ОХУ-ын

ЭХХШтХ-ийн 2013 оны 04 дүгээр сарын 26-нд нэмэлт, өөрчлөлт оруулж, уг хууль нь 2014 оны 05 дугаар сарын 07-оос хүчин төгөлдөр болсон бөгөөд энэ өөрчлөлтийн гол чухал нь шүүхээс хэргийг прокурорт буцаах тухай асуудал байжээ. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд өөрийн уламжлал, эх газрын болон англо-саксоны эрх зүйн уламжлалыг харьцуулан сайтар судалж байна. Нэмэлт өөрчлөлтийн шийдэлд хүрсэн юм байна. ОХУ-ын ЭХХШтХ-ийн 237 дугаар зүйлд оруулсан өөрчлөлтөөр мөрдөн байцаах ажиллагааны дутууг нөхөж гүйцээлгэх зорилгоор буцааж байсныг бүрмөсөн болиулж шүүхээс эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэхэд саад учруулж буй нөхцөл байдлыг арилгуулах зорилгоор хэргийг прокурорт буцаах боломжийг хуульчилсан байна. Ингэхдээ буцаах 2 тохиолдлыг дараах байдлаар тодорхойлсон:

1. Шүүхэд хэргийг шилжүүлсний дараа яллагдагчид холбогдох нийгэмд аюултай шинэ үр дагавар үүсч, түүнд нь илүү хүнд ял сонсгох шаардлагатай болсон.

2. Эрүүгийн хэргийн талаар өмнө нь гаргасан шүүхийн тогтоол, магадлал, захирамжийг дээд шатны шүүхээр хүчингүй болгосон бөгөөд хүчингүй болгох шийдвэрийн үндэс болсон шинэ болон дахин үүссэн нөхцөл байдал нь яллагдагчид илүү хүнд ял сонсгох үндэслэл болж байгаа.

Энэ 2 тохиолдолд хэргийг анхан, давж заалдах, хяналтын шатны алинаас нь ч буцааж болохоор шүүхэд заасан.

Өмнө нь ийм үндэслэлүүдээр шүүхээс хэргийг буцааж байгаагүй. Гэхдээ шүүх энд заасан 2 тохиолдолд өөрийн санаачлагаар бус прокурорын хүсэлтээр буцааж болох юм байна. Хэргийг “нэмэлт мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах” ойлголтыг ОХУ-д буцааж болох 2 тохиолдлыг хуульчилсан нь шүүн таслах ажиллагаанд саад болох нөхцөл байдлыг арилгах зорилготой болж шинэчлэгдсэн. Гэхдээ тухайн үндэслэлээр буцаах нь зөвхөн прокурорын хүсэлтээс шалтгаалахаар хуульчилсан байна.

Прокурорын хүсэлтээр буцааж болох дээрх 2 тохиолдлоос гадна, шүүх өөрийн санаачлагаар буцааж болох зарим тохиолдлыг мөн хуульд заасан. Эдгээр нь шүүн таслах ажиллагааг үргэлжлүүлэн явуулахад саад болох нөхцөл байдлуудтай холбоотой.

- Яллах дүгнэлийг үйлдэхдээ ЭХХШтХ-ийн заалт зөрчсөн;
- Яллагдагчид яллах дүгнэлтийг гардуулаагүй, эсхүл хуульд заасан хугацаанд гардуулаагүй;
- Хэд хэдэн хэргийг нэгтгэх шаардлагатай болсон гэсэн үндэслэлүүдээр шүүх өөрийн санаачлагаар хэргийг прокурорт буцаах боломжтой болсон.

ХБНГУ-ЫН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД

ХБНГУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 1877 онд батлагдсан бөгөөд Европын хамгийн “анхдагч” хуулиудын нэг гэж тооцогддог ба өнөөгийн редакцияар 1987 оноос хойш үйлчилж буй. Эрүүгийн хэрэг хянан

шийдвэрлэх ажиллагааны үе шатыг шүүхийн өмнөх, шүүхэд шилжүүлэх, шүүх ажиллагаа гэх зэргээр манайхтай төсөөтэй тоймлон үе шатад хувааж үзэх боломжтой ч зарчмын шинжтэй олон ялгаа байдаг. Тухайлбал, шүүхийн өмнөх үе шатыг эрүүгийн хэрэг үүсгэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаа явуулах гэхчлэн салгадаггүй. Шүүхэд хэрэг очихоос өмнөх ажиллагаанд прокурор голлох үүрэгтэй оролцдог. Гэмт хэрэг гарсан тухай үндэслэл бүхий гомдол, мэдээлэл нь цагдаа, шүүхийн мөрдөн байцаагч, прокурорын хувьд процессын ажиллагааг эхлэх үүргийг үүсгэдэг.

Баримт нотолгоо нь яллахад хангалттай гэж үзвэл прокурор яллагдагчид ял сонсгох ба улмаар мөрдөн шалгах, яллах ажиллагаа хангалттай хийгдсэн бол Германы ЭХХШТХ-ийн 170.1-д зааснаар харьяалах шүүхэд яллах дүгнэлт бичиж хүргүүлдэг". Бусад бүх тохиолдолд мөн хуулийн 170.2-ыг баримтлан хэргийг хэрэгсэхгүй болгоно. Нэмэлт шалгалт хийлгэхээр хэргийг цагдаад ч юм уу, өөр хэн нэгэнд буцаах тухай зохицуулалт байхгүй.

Шүүхийн шат: прокурор яллахаар эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлсэн бол харьяалах шүүх уул хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх эсэхийг тогтоох ажиллагааг явуулж эхэлдэг. Энэ ажиллагаа нь гэм буруугүй этгээд эрүүгийн хэрэгт яллагдан, шүүх хуралдаанаар шүүгдэх явдлаас урьдчилан сэргийлэх зорилготой. Энэ шатанд шүүгч яллагдагчийг дуудан ирүүлж, түүнд яллах дүгнэлтийн хувь хуулбарыг танилцуулж, хэрэгт авагдаагүй бусад нотлох баримт цуглуулж авахуулах хүсэлт бий эсэх, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхэд татгалзал бий эсэхийг лавлана. Хуулийн 202 дугаар зүйлд "...хэргийн бодит байдлыг сайтар судалж тогтоох зорилгоор шүүх нэмэлт нотлох баримт цуглуулахаар шийдвэрлэж болох ба түүнд хэн ч гомдол гаргах эрхгүй" гэж заажээ. Үүний дараа шүүх хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэх, эс хэлэлцэхээ шийдвэрлэдэг. Эс хэлэлцэх тохиолдолд хэргийг хэрэгсэхгүй болгох, эсхүл түдгэлзүүлэх шийдвэрийн аль нэгийг гаргана. Хэлэлцэхээр бол прокурорын ялласан хэмжээнд, эсхүл сонсгосон ялыг ихэсгэх, багасгах эсэхийг шийдвэрлэдэг. Дүгнэж хэлбэл, шүүхийн шатанд хэргийг дахин шалгуулахаар прокурорт буцаах талаар зохицуулалт огт байхгүй бөгөөд прокурор ялыг нэмэгдүүлэх санал тавьсан тохиолдолд ч хуралдааныг завсарлаж байгаад л хэргийг нэг мөр шийдвэрлэдэг аж.

ФРАНЦ УЛСЫН ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬ

1958 оноос хойш хүчин төгөлдөр үйлчилж байгаа Францын Эрүүгийн байцаан шийтгэх хууль улсын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа нь бүхэлдээ мөрдөн шалгах тогтолцоотой. Шүүхийн мөрдөн байцаагчийн оролцоо процесс ажиллагаанд их нөлөөтэй. Эрүүгийн процесс нь шүүхийн өмнөх болон шүүхийн гэсэн хоёр шаттай. Хавтаст хэрэгт хангалттай нотлох баримт цугларсан бөгөөд шүүхэд хэргийг шилжүүлснээр шүүхийн өмнөх шат дуусгавар болно.

Энэ хуулийн "Зайлшгүй авах шаардлагатай бус болон онцгой тохиолдолд авах шаардлагатай арга хэмжээ" хэмээх зүйлүүд /283- 287/-эд шүүхийн өмнөх шатанд мөрдөн байцаах ажиллагаа дутуу явагдсан, түүнчлэн хэргийг нэг мөр

шийдвэрлэхэд тодорхой үйл баримтыг тогтоох гарцаагүй шаардлагатай гэж үзвэл даргалагч шүүгч захирамж гаргаж, мөрдөн шалгах ажиллагаа явуулахаар заасан байна. Процесс ажиллагааны шүүхийн өмнөх шат руу хэргийг буцаах тухай зохицуулалт энэ хуульд мөн алга байна.

ЛАТВИ УЛСЫН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬ

Социалист систем, ЗХУ-ын задралын дараа тусгаар тогтносон улсуудын дунд Балтийн тэнгэсийн гэгдэх улсуудын, тухайлбал: Латвийн үндэсний хууль тогтоомжоо Европын холбооны хатуу стандарт, шаардлагад амжилттай нийцүүлсэн туршлагыг дэлхийн олон улсад жишиг болгодог. Иймд дээр товч танилцуулсан ОХУ, ХБНГУ зэрэг эх газрын эрх зүйн өндөр соёл, уламжлалын төлөөлөл болсон улсын ЭХХШТХ-ийг судлахын сацуу, Латвийн хуулийн бүтэц, онцлогийг харьцуулан судлах нь эрдэм шинжилгээний онол, практикийн ач холбогдолтой байж болно.

Латвид өдгөө мөрдөж буй ЭХХШТХ-ийг 2005 онд баталсан бөгөөд түүнд шүүхэд шилжүүлсэн хэргийг нэмж шалгуулахаар шүүхийн өмнөх шатанд буюу прокурорт буцаах талаар зохицуулалт огт байхгүй юм. Гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг дээрх хуулиар эрх олгосон байгууллага, албан тушаалтан прокурорт ирүүлдэг, прокурор уул ажиллагааг хянах шинжтэй чиг үүрэг хэрэгжүүлдэг. Улмаар гэмт хэргийн нөхцөл байдлыг баримт нотолгоогоор хангалттай тодруулсан гэж прокурор үзвэл гэмт хэрэгт сэрдэгдэж буй этгээдэд ял сонсгож, хэргийг шүүхэд шилжүүлдэг. Гэхдээ шүүхийн өмнөх процесс ажиллагааг явуулах, дуусгавар болгох олон хувилбарыг хуульчилсан /411 дүгээр зүйл/ байна.

Хуульд шүүхийн урьдчилсан хуралдаан, зөвлөгөөн гэх зэрэг тусгайлсан үе шатыг гаргаагүй боловч шүүхийн өмнөх процесс ажиллагаа хэрхэн дуусч байгаагаас шалтгаалж анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа өвөрмөц онцлогтой явагдана.

Латви Улсын ЭХХШТХ-ын 411 дүгээр зүйлд зааснаар прокурор шүүхийн өмнөх процесс ажиллагааг дор дурдсанаар дуусгавар болгох:

- Эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх тогтоол гаргаж, хэргийг харьяалах шүүхэд шилжүүлэх,
- Эрүүгийн хэргийг шүүхэд хойшлуулшгүй ажиллагааны журмаар шилжүүлэх тогтоол гаргах,
- Эрүүгийн хэргийг шүүхэд хялбаршуулсан /хорогдуулсан, богиносгосон/ журмаар шилжүүлэх тогтоол гаргах,
- Эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэхээр яллагдагчтай тохиролцох журмаар,
- Яллагдагчид ял хэрэглэхээр урьдчилан тохирох,
- Эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож, эрүүгийн хариуцлагаас тэнсэж чөлөөлөх журмаар,
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгсэхгүй болгох тогтоол гаргах,

- Эмнэлгийн болон хүмүүжлийн шинжтэй албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шүүхэд эрүүгийн хэргийг шилжүүлэх тогтоол гаргах.

Жишээ болгож эрүүгийн хэргийг шүүхэд хойшлуулшгүй ажиллагааны журмаар шилжүүлэх зохицуулалтын талаар товч дурдвал:

- Тухайн зохицуулалтыг ямар тохиолдолд хэрэглэж болох /гэмт хэрэг үйлдсэн этгээдийг хэргийн газарт нь баривчилсан, хэргийн ангилал, ажлын 3 хоногт дуусгах боломж г.м./
- Хэрэг гарсан нөхцөл байдал, хохирогч, гэрч, хохирлын хэмжээг тодруулах гэх зэрэг шаардлагатай ажиллагааг маш түргэн гүйцэтгээд материалыг хангалттай болсон гэж прокурор үзвэл шүүхэд хэргийг өгдөг. Тэгэхдээ шүүх хуралдааныг түргэн хийхээр прокурор шүүхтэйгээ зөвшилцдөг ба энэ хугацаа хэрэг хүлээн авснаас хойш 3-10 хоногийн дотор байна. Эрүүгийн хэргийг шүүхэд хойшлуулшгүй ажиллагааны журмаар шилжүүлэх тогтоол нь холбогдох этгээдийг эрүүгийн хариуцлагад татсан шийдвэр болдог ба уул тогтоолыг хэргийн материалын хуулбарын хамтаар яллагдагчид, мөн түүнчлэн хохирогчид прокурор гардуулан өгөх ёстой. Энэ шийдвэрт гомдол гаргахгүй ба шүүхийн ажиллагаа ердийн журмаар явагдана.

Хэрэг хүлээж авсан шүүх мөн хуулийн 486 дугаар зүйлд зааснаар хэргийн харьяалал, яллах шийдвэр нь байгаа эсэх, түүний хувь хуулбарыг яллагдагчид гардуулж өгсөн эсэх, хэргийн материалтай танилцсан эсэх зэрэг асуудлыг тодруулах ба харьяаллын бус бол хэргийг зохих шүүхэд нь шилжүүлж, бусад тохиолдолд “дутагдал”-ыг арилгуулахаар дээд шатны прокурорт хэргийг шилжүүлэн өгдөг. Түүнчлэн 488 дугаар зүйлд зааснаар шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааг аль болох түргэн эхлэх ёстой ба хэрэг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор хуралдааны товыг тодорхойлсон байх ёстой.

Тус улсын ЭХХШТХ-д буй манайхаас ялгаатай зохицуулалтын нэг нь шүүх хуралдаанд оролцсон прокурор урьд сонсгосон ялыг багасгаж, нэмэгдүүлж өөрчлөх шаардлагатай бол энэ тухай үндэслэлээ танилцуулж ялыг өөрчлөх үүрэгтэй /461 дүгээр зүйл/. Ял өөрчлөх тохиолдолд:

- хэргийн бодит байдал өөрчлөгдөхгүйгээр ялыг хөнгөрүүлж өөрчилж буй бол шинээр сонсгож буй ялын талаар шүүх хуралдааны тэмдэглэлд тэмдэглэнэ
- ялыг хүндрүүлсэн буюу сонсгосон ялыг хөнгөрүүлж өөрчилснөөр хэргийн бодит нөхцөл байдал өөрчлөгдсөн бол шүүх, яллагдагч, түүний өмгөөлөгчийн шаардсанаар прокурор нь шинээр ял сонсгох тухай бичгээр мэдэгдэнэ. Ялыг өөрчлөн сонсгоход хугацаа хэрэгтэй бол прокурорын хүсэлтээр хуралдааныг завсарлаж болно.
- хэрэв шүүх хуралдааны явцад хэргийн өөр нөхцөл байдал тогтоогдож, ялыг хүндрүүлэн өөрчлөх шаардлагатай болвол прокурорын хүсэлтээр байцаан шийтгэх зайлшгүй ажиллагаа явуулах боломж олгохоор шүүх хуралдааныг завсарлах ба энэ хугацаа нэг сараас илүү байж болохгүй.
- шинэ ял сонсгож буйтай холбогдож яллагдагч, түүний өмгөөлөгч,

хоширогч, түүний төлөөлөгчийн хүсэлтээр шүүх хуралдааныг хойшлуулж, шинээр сонсгож буй ялтай танилцах боломж олгодог байна /462 дугаар зүйл/.¹²

ДОЛОО. ЗӨВЛӨМЖ

Аргачлалын 9-д заасны дагуу энэхүү үнэлгээний тайлангийн 5 дахь хэсгийн “Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулсан дүгнэлт”, 6 дахь хэсгийн “Олон улсын болон бусад улсын хууль эрх зүйн зохицуулалттай харьцуулсан байдал” зэргийг харьцуулан судалсаны үндсэн дээр дараах зөвлөмжийг боловсрууллаа. Үүнд:

1. Хэргийг буруу тусгаарласан, мөрдөн шалгах ажиллагаа явуулахад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн, шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй мөрдөн шалгах ажиллагааг хийлгэх бол хэргийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн үеэр буцааж, хуульд нийцээгүй шийдвэр гарахаас урьдчилан сэргийлэх зохицуулалтыг хэвээр үлдээх нь зүйтэй.
2. Монгол Улсын Үндсэн хууль, эрүүгийн болон эрүүгийн процессын эрх зүйн амин сүнс болсон зарчимд нийцээгүй шүүхийн шатнаас хэргийг прокурорт буцаах зохицуулалтыг ХБНГУ, ОХУ, Франц, Латви болон бусад дэлхийн улс орнуудын жишигт нийцүүлэн бүр мөсөн халах нь зүйтэй.
3. Давж заалдах болон хяналтын шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрийг бүхэлд нь үгүйсгэж, хэргийг прокурорт буцаадаг манай орны эрх зүйн уламжлалд байгаагүй, социалист тогтолцооны үед анх гарч ирж, 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар хэрэгжиж байсан зохицуулалтыг халах шаардлагатай. Хүний эрхийг ноцтой зөрчиж буй уг зохицуулалтыг ахин сэргээхгүй байх нөхцлийг мөн бүрдүүлэх шаардлагатай юм.
4. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад оролцогчийн эрхийг зөрчсөн, нотлох баримт цуглуулж, бэхжүүлэх талаар хуульд заасан журам зөрчигдсөн, эсхүл шүүх хуралдаан дээр талуудын мэтгэлцээн, нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэж шүүгдэгчид холбогдох хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэхээр бол прокурорын хүсэлтийг үндэслэж хэргийг прокурорт буцаахгүйгээр шүүх хуралдааныг завсарлах, зайлшгүй нэмэлт мөрдөн байцаалт явуулах нөхцлийг бүрдүүлэх Латви, Франц улсын жишигт нийцүүлэн зохицуулах нь манай орны хувьд зохимжтой байна.

¹² Хууль зүйн үндэсний хүрээлэн “Шүүхээс эрүүгийн хэргийг нэмэлт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт хийлгэхээр прокурорт буцаах нь” сэдэвт судалгааны тайлан 2017 он, х.8-13

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хавсралт 1

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ялгаварлан гадуурхсан зохицуулалт агуулаагүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Энэхүү хуулийн төсөл нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэх зохицуулалт шинээр бий болгоогүй ч олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж байгаа болно.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Эрүүгийн процесст олонхи, цөөнхи гэж ялгарахгүй бүгд тэгш эрхтэй оролцоно.

	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төсөл нь иргэдийн үндсэн эрх, хэргийн оролцогчдийн хуульд заасан эрх, үүргийг эдлэх боломжийг бүрдүүлж байгаа тул эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй иргэд байхгүй байна.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Яллагдагчийн гэм буруутай эсэхийг тогтоох явц гэм буруугийн зарчимд нийцэж, шүүгчдэгчийг хоёр ба түүнээс дээш яллах, гэм бурууг нь нэгээс дээш удаа авч хэлэлцэх асуудал арилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шударга ёсны зарчимд нийцэн өмгөөлөгчийн өмгөөлөх нотлох баримтаа үнэлүүлэх эрх хангагдана. Ял завшуулах, авилгын сүлжээ бий болгох боломжийг хааснаар иргэний шударга шүүхээр шүүлгэх эрх хэрэгжих бололцоонд эерэг үр дүн гарна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 тоот тогтоолоор баталсан Авлигын эсрэг НҮБ-ын конвенцид Монгол Улс 2005 онд нэгдэж орсон бөгөөд тус конвенцийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөвлөмжид нийцэж байгаа.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Хариуцлагын асуудал Эрүүгийн болон Зөрчлийн хуульд тусгагдсан.
	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ	Тийм	Үгүй	Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх,

агуулсан эсэх	нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх			хууль ёсны зарчмыг бэхжүүлэх зорилготой байна.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй байна.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Яллагдагч, шүүгдэгч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь эрх агуулагчид хамаарна.
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Дээр дурдсан этгээдүүд эмзэг байдалтай гэж тодорхойлолтод хамаарахгүй байна.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Дээрх үндэслэлээр
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	Үгүй	Дээрх үндэслэлээр
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Шүүх, прокурор, мөрдөгч үүрэг хүлээгчид хамаарна.
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Шаардлагагүй.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хавсралт 2

Үзүүлэх нөлөө:	үр	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар		1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал		2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон		3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

захиргааны зардал	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Нэмэлт зардал гарахгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх,	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх			
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Одоо байгаа хуульд зааснаас өөрөөр шууд нөлөө үзүүлэх зүйл байхгүй. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сунжирснаас үүдэн гарах зардлыг хэмнэнэ.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Шүүхийн байгууллагын системд ажлын байр бий болгохгүй.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Өндөр үнийн дүнтэй эрүүгийн хэрэг маргаан дээр ял завших боломжийг хааснаар улсын төсөвт орох ёстой байсан хөрөнгө орно.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	

10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хавсралт 3

Үзүүлэх нөлөө:	үр	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гүйцэтгэх үүргээ хуульд заасны дагуу хэрэгжүүлэх шаардлагатай болно.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэгээр нөлөөлөх болно. Гэм буруутай, гэм буруугүй гэж олон дахин гэм буруугийн асуудлыг авч хэлэлцдэг хүний эрхийн зөрчлийг арилгаж, ганцхан яллах талын байр суурьнаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагддаг

				практикийг засч, иргэд эрүүгийн хэргээ түргэн шуурхай шийдвэрлүүлэх нөхцөл бүрдэнэ.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	сөрөг нөлөө үзүүлэх эсэх			
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг зөв олж тогтоон, гэм буруугүй этгээдийг хилсээр шийтгэх явдлаас урьдчилан сэргийлж, гэмт хэрэг үйлдсэн этгээд ял завших боломжтой хуулийн хийдлийг залруулна.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Гэмт хэргийг шуурхай бүрэн илрүүлэх ажиллагаанд эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Сөрөг нөлөө үзүүлэхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Хавсралт 4

Үзүүлэх нөлөө:	үр	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар		1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч		2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах		3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Усны нөөц		4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
		4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй